

БНХАУ-ААС МОНГОЛ УЛС РУУ ЧИГЛЭСЭН ХӨРӨНГИЙН УРСГАЛ, ТҮҮНИЙ ҮР ӨГӨӨЖ

Д.Дагийсүрэн *

Товч агуулга:

Энэхүү өгүүлэлд манай улстай хамгийн урт хилийн шугамаар холбогддог хөрш улс болох БНХАУ-аас Монгол улс руу чиглэсэн хөрөнгийн урсгал сүүлийн жилүүдэд яагаад эрс нэмэгдэх болов? Тэдгээр хөрөнгийн урсгалын үр өгөөж, сөрөг нөлөөг тодруулж, хөрөнгийн урсгалыг ямар, ямар төсөл хөтөлбөрүүдэд зарцуулж байгааг судлан өөрийн үнэлэлт дүгнэлт өгөх оролдлого хийлээ. Манай орны хөрөнгийн хомсдолтой эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж чухал үүрэгтэй хэвээр байна. Төр засгаас идэвхитэй бодлого явуулсны үрээр манай улсад хийгдэж буй гадаадын хөрөнгө оруулалт ялангуяа БНХАУ-аас оруулж буй хөрөнгө оруулалт, зээл, тусламж сүүлийн жилүүдэд өссөөр байна. Харин тэдгээр хөрөнгө оруулалт болон зээл тусламжийг хэрхэн зарцуулж, ашиглаж буй байдалд дүн шинжилгээ хийсэн судалгааны зохиол бүтээл хомс байгаа учир тэрхүү чухал асуудалд бага боловч хувь нэмэр оруулах үүднээс энэхүү өгүүлийг бичлээ.

Түлхүүр үг: Монгол, Хятад, хөрөнгө оруулалт, зээл, тусламж

1. Монгол Улсад оруулж буй БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалт

Манай улс гадаад орчноос шууд хамааралтай, эмзэг эдийн засагтай жижиг улс. Хоёр их гүрний дунд, далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжтай бус нөхцөлд, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспортод түшиглэсэн жижиг эдийн засагтай, хүн ам цөөнтэй орон тул гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй.

Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дараах давуу болон сул талууд байдаг. Давуу талууд:

* Д.Дагийсүрэн- БНХАУ-ын Жилиний Их сургуулийн докторант

- Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрдсэн
- Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой Олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан
- Дэлхийн худалдааны байгууллага, НҮБ болон холбогдох бусад олон улсын байгууллагад гишүүнээр элссэн
- Нээлттэй эдийн засгийн бодлоготой
- Татварын тогтолцоо, хөнгөлөлт, чөлөөлөлтийн систем
- Хоёр их гүрний дунд, асар том зах зээлд ойр оршдог
- Байгалийн томоохон нөөц ордуудтай

Дутагдалтай талууд:

- Хууль эрх зүй, эдийн засгийн тогтворгүй байдал / эмзэг эдийн засагтай жижиг улс/
- Улс төрийн тогтворгүй байдал
- Инфляци
- Дэд бүтцийн хөгжил сул
- Авилга, хүнд суртал
- Далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжгүй нөхцөл¹

Монгол улс шинэ үндсэн хуулиа тунхаглан ардчиллын замыг сонгон нээлттэй гадаад бодлого явуулж, хөрөнгө оруулалтын орчноо улам тодорхой, ил тод болгосон нь Гадаадын төдийгүй Хятадын аж ахуйн нэгжүүдийг Монголд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлсэн. Монгол Улсын засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн акт нь "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль" байсан бөгөөд энэ хуулинд хөрөнгө оруулалтын илүү таатай орчинг бий болгох зорилгоор нилээд хэдэн удаа засвар өөрчлөлт оруулж байсан боловч 2013 оны 10 сарын 3-ны өдөр Монголын УИХ-аас "Хөрөнгө оруулалтын тухай хууль"-ийг шинэчлэн батлан гаргаж 2013 оны 11 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Уг хууль нь 7 бүлэг, 24 зүйлтэй юм.²

Хөрөнгө оруулалтын хуульд зарчмын чухал асуудлуудыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

1. Хөрөнгө оруулагчийг гадаад дотоод гэж ялгаварлахгүй нийтлэг эрх зүйн зохицуулалт, хамгаалалт, баталгаа бий болгох,

2. Өмнөх эрх зүйн зохицуулалтад стратегийн ач холбогдол бүхий салбарт эрдэс баялаг, банк, санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо гэсэн салбаруудыг хамааруулж байсныг өөрчилж, стратегийн салбар гэж тусад нь ялгаагүй,
3. Гадаадын хөрөнгө оруулагчийг ерөнхийд нь хувийн болон төрийн гэж ангилж, хувийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн хэмжээ тухайн аж ахуйн нэгжид 25 хувиас дээш гарах тохиолдолд эрхэлсэн яамнаас зөвшөөрөл өгч байх,
4. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахын тулд төслийн үр ашиг дээр нь тулгуурлан тодорхой хугацаанд татварыг нь тогтворжуулах тогтолцоог тусгажээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ нь 15 тэрбум төгрөгөөс давсан, эдийн засгийн хөгжилд нийцтэй, байгаль орчинд ээлтэй, шинэ технологи нэвтрүүлсэн, ажлын байр нэмэгдүүлсэн төслүүдэд 5-10 жилийн хугацаанд зарим татварын хувь хэмжээг тогтвортой байлгах,
5. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, өөрийн улсын хөрөнгө оруулалтын орчны талаар бүх талын мэдээлэл, сурталчилгааг явуулах агентлагийг байгуулахаар тус тус тусгажээ³
6. 1990 оноос хойш өнөөг хүртэл Монгол улсад 110 улс орон, тусгай статустай бүс нутгуудаас 11 642 гадаадын хамтарсан болон 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бүртгэгдэж, нийт 9. 826 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.⁴

Хятадын бизнес эрхлэгчид 1990 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч орнуудыг сүүлийн 10 гаруй жил тэргүүлсээр байна. БНХАУ-ын хөрөнгө оруулагчид геологи уул уурхайн судалгаа, эрэл хайгуул, олборлолт худалдаа, нийтийн хоол, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэр зэрэг салбарт хөрөнгө оруулж байна. Тухайлбал: «Эс энд Ти Голд», «Төмөртэйн хүдэр», «Доншен газрын тос», «Петрочайна Тамсаг» ХХК зэрэг компаниуд геологи, уул уурхай, газрын тосны салбарт, «Богд холдинг» «Зүй-лүн» зэрэг компаниуд барилга, барилгын материалын

үйлдвэрлэлийн салбарт, «Монгол хунхуа» Топлает текстил» зэрэг компаниуд оёдлын үйлдвэрийн салбарт, «Эрдос Монголия» кашмир продактс» зэрэг компаниуд ноос ноолуур боловсруулах салбарт тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн жилүүдэд Хятад улсаас гадаад орнуудад хамгийн ихээр хөрөнгө оруулж буй салбар бол уул уурхай, газрын тосны хайгуул, олборлолт юм⁵. Энэ нь тус улсын эдийн засаг тухайлбал аж үйлдвэр нэн хурдацтай хөгжиж байгаа боловч эрчим хүчний түүхий эд болон бусад төрлийн түүхий эдээр ихээхэн гачигдаж байгаатай шууд холбоотой. Ялангуяа 2003 онд Ху Зиньтао дарга Монголд айлчлах үеэр хоёр тал "байгалийн баялгийг олборлох, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг нь хөгжлийн чухал салбар болгохоор тохиролцсон нь чухал түлхэц үзүүлжээ. Хятад улс 2004 онд Монгол дахь хөрөнгө оруулалтынхаа 65%-ийг буюу 73 сая ам.долларыг уул уурхай, ашигт малтмалын эрэл хайгуулын салбарт төвлөрүүлж, барилга нийтийн хоолны салбарыг ардаа орхисон.⁶

Хятадаас Монголд оруулсан шууд хөрөнгө оруулалтын хэмжээ тасралтгүй нэмэгдэж, хурдан өсч байгаа нь зөвхөн Монгол Улсад гарч байгаа үзэгдэл биш, Хятадын эдийн засгийн хөгжлийг дагалдаад, гадаадад оруулж буй хөрөнгө оруулалтын цар хүрээ, хэмжээ ч мөн хурдан өсч байна. БНХАУ-ын гадаадын шууд хөрөнгө оруулалтын 2010 оны статистикаас харахад, Монгол улсад нийт 1.43 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт ороод байгаа нь хилийн чанад дахь Хятадын нийт хөрөнгө оруулалтын 0.5 хувьтай тэнцэж байна.⁷ Хятадаас Монголд оруулах хөрөнгө оруулалтын хурдац нэмэгдэж буйн бас нэг шалтгаан бол Хятад, Монгол хоёр орны эдийн засгийн бүтэц адилгүй улмаас 2 талын эдийн засгийн харилцан нөхөх чанарт оршино. Монгол Улсын зэс, нүүрс, төмөр, газрын тос зэрэг ашигт малтмалын нөөц баялаг нь хятадын өндөр хурдацтай эдийн засгийн хөгжилд дутагдаж буй түүхий эдийг нөхөхөд хэрэгтэй юм. Дээр нь газар зүйн ашигтай байрлалтай болохоор Хятад улс улам бүр том үйлдвэр, аж ахуйн газар нээж ажиллуулах хөрөнгө оруулалтыг Монголын зах зээлд оруулахыг хүсдэг.

«Алс дорнодын эдийн засгийн тойм» /»Far Eastern economic review»/ сэтгүүлд «Бусад улс, хөрөнгө оруулагчдын эдэлж чадахааргүй тийм их давуу эрхийг Хятад улс Монголд эдэлж байна» гэж дурдаад, түүний гол шалтгаан нь:

- *Нэг, газар нутгийн ойр байдал:* Хятадаас болон Хятад руу хийх тээврийн зардал нь манай бусад худалдааны түншүүдийнхээс хямд, дөт байна. Тяньзин боомт хүрэх хугацаа Оросын Алс Дорнодын боомтоос 5 дахин бага.
- *Хоёрт, зах зээлийн харилцан уялдаа:* Хятадад Монголын эрдэс болон ой модны нөөц баялаг, амьтны гаралтай бүгээгдэхүүн хэрэгтэй байгаа бол Монголд өргөн хэрэглээний бараа, цахилгаан тоног төхөөрөмж, барилгын материал шаардлагатай байна.
- *Гуравт, бие биеэ мэдэх байдал:* Хятад, Монгол хоёр нь бие биенийгээ мэдэхийн хувьд урт хугацаанд сайн, муу ихээхэн туршлага хуримтлуулсан орнууд юм. Хятадын ӨМӨЗО нь тус улсыг монгол хэлтэй зах зээлийн агентуудаар хангах гол эх үүсвэр, нийлүүлэгч нь болж байна гэж дүгнэжээ.

Монголын хувьд ГШХО-той холбоотой нэг чухал асуудал бол гадаад орнуудаас орж буй хөрөнгө оруулалтын тэнцвэрт байдлыг хадгалах явдал юм. Тэнцвэрт байдлыг хадгалах нь үндэсний аюулгүй байдлыг хангах нэгэн чухал хүчин зүйл билээ. УИХ-ын 2010 оны 48-р тогтоолоор шинэчлэн баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын "Эдийн засгийн аюулгүй байдал" хэсгийн 3.2.2.2-т "Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална", Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална" гэж заасан байдаг.⁸ Тэгвэл 1990-2011 оны хооронд Монгол улсад нийт 9.8 тэрбум ам.долларын хөрөнгө орсноос БНХАУ-ын хөрөнгө оруулалт 3.48 тэрбум ам.доллар буюу 1/3-ээс бага зэрэг даваад байна. Монголд бүртгэгдсэн нийт гадаадын хөрөнгө оруулалтыг улсаар нь

авч үзвэл БНХАУ 35%, Нидерланд 22%, Виржини арлууд 9%, Люксембург 5%, Сингапур 5%, Канад 5%, БНСУ 3% эзэлж байна.⁹ Гэхдээ сүүлийн үед нийт хөрөнгө оруулалтад эзлэх Хятадын хувь хэмжээ буурах хандлагатай байна. Хятадын хөрөнгө оруулалт 2004 онд гадаадын нийт хөрөнгө оруулалтын 39.4%, 2006 онд 46.6%, 2008 онд 55.7%, 2009 онд 60%-ийг тус тус эзэлж байсан бол 2010 онд 51%, 2011 онд 35% байжээ.¹⁰ Эндээс харахад Хятадын хөрөнгө оруулалтын хэмжээ Монгол улсын ҮАБ-ын үзэл баримтлалд заасан нэг орны хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй гэсэн заалттай бараг дөхөж ирсэн байна. Хятадын хөрөнгө оруулалт 51%¹¹ -иас 35% хүрч буурсны гол шалтгаан бол 2011 онд Хятадын хөрөнгө оруулалт буурсанд биш, харин бусад орны хөрөнгө оруулалт огцом 5 дахин өсөж, 4.9 тэрбум ам.доллар болсонтой холбоотой юм. 2011 онд Хятад 1.0 тэрбум ам.доллар оруулсан бол Нидерланд улс 1.8 тэрбум ам.доллар тус тус оруулсан байна.¹²

Нийт гадаадын хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл 73.7% буюу 7.2 тэрбум ам.долларыг геологи, уул уурхайн салбарт, 15.6% буюу 1.53 тэрбум ам.долларыг худалдаа, нийтийн хоолны салбарт, 1.58% буюу 155.5 сая ам.доллар нь банк санхүүгийн салбарт, 1.1% буюу 108.0 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хөнгөн үйлдвэрийн салбарт тус тус оруулсан байна.¹³ Харин Гадаадын хөрөнгө оруулалтын газрын статистикаар Хятадын Монгол дахь хөрөнгө оруулалтаас 2.5 тэрбум ам.доллар буюу 71.8% нь геологи, уул уурхайн салбарт ноогдож байна.¹⁴ Үүнээс үзэхэд гадаадаас болон БНХАУ-аас орж ирж байгаа хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь дан ганц уул уурхайн салбарт орж өрөөсгөл бүтцийг бий болгож байгаа нь олон тулгуурт эдийн засгийн бүтэц бий болгох тухай төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна. Иймд өөрийн орны нөөц боломжид тулгуурлан дотоодын аж ахуй нэгжүүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, манай орны хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулах хөрөнгө оруулалтыг зөвхөн уул уурхайн салбарт төдийгүй, холбоо мэдээлэл, барилгын материал, аялал жуулчлал, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр зэрэг салбарт ч мөн ихээр оруулах хэрэгтэй байна.

Эдийн засгаа дархлаажуулахын тулд боловсруулах үйлдвэрлэлийн салбар, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг бусад салбарыг хөгжүүлэх талаар төрөөс тодорхой бодлогыг хэрэгжүүлж, уул уурхайн салбараас хэт хараат байгаа өнөөгийн нөхцлөөс аажим аажмаар гарах алхмуудыг хийх хэрэгтэйг дээрх тоон үзүүлэлтүүд харуулж байна.

Мөн Хятадын хөрөнгө оруулалттай компанийг тооны хувьд авч үзвэл 1990 онд 1 компани, 1993 онд 12 компани бүртгүүлж байсан бол 2008 оны байдлаар БНХАУ-ын 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай 4595 аж ахуйн нэгж бүртгэгдсэн бол 2009 онд 2.3 тэрбум ам.долларын хөрөнгө **оруулалттай 4927** компани, 2010 онд 2.5 тэрбум ам долларын хөрөнгө оруулалттай 5303 компани, 2011 **онд** 2.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай 5756 аж ахуйн нэгж бүртгэгджээ. Үүнээс 136 нь уул уурхайн компани, дийлэнх буюу 4072 нь худалдаа, нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа явуулдаг гэж бүртгэгджээ.¹⁵ Үүнээс харахад Хятад улсаас Монголд оруулж байгаа хөрөнгө оруулалтын төслийг тооноос чанар луу шилжүүлж, хоёр орны эдийн засагт нэмэр хандив болохуйц томоохон хэмжээний төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явдал тулгамдсан асуудал болж буйг харж болно.

Харин Монгол Улсаас БНХАУ-д хөрөнгө оруулалт хийсэн пүүс, компани аж ахуйн нэгж маш бага байна. Монголын аж ахуйн нэгжүүд Хятадад ихэвчлэн төлөөлөгчийн газар нээх, тээвэр зуучлалын салбарт үйл ажиллагаа явуулж байна. Үүний гол шалтгаан нь манай аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал, өрсөлдөх чадвар сул, техник, технологийн түвшин хүрэлцэхгүй байгаа зэргээс хамаарч байгаатай холбоотой юм.¹⁶

Гадаадын хөрөнгө оруулалт ихээр орж ирснээр тухайн улсад эерэг болон сөрөг нөлөөллийг бий болгодог. Тухайлбал Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дотоодын 67 мянган боловсон хүчнийг ажлын байраар хангасан бөгөөд 2500 гаруй гадаадын мэргэжилтнүүд Монгол улсад ажиллаж удирдлагын шинэ шинэ арга технологийг нэвтрүүлсэн нь маш том оюуны хөрөнгө оруулалт юм.¹⁷

2011 оны байдлаар хамгийн их татвар төлсөн уул уурхайн 10 компаниас хоёр нь Хятадын хөрөнгө оруулалттай

Цайрт минерал ХХК, Чинхуа МАК Нарийн сухайт ХХК байна. Чинхуа МАК Нарийн сухайт ХХК бол Нийгмийн хариуцлагаа сайн ухамсарлаж Монгол улсын эдийн засагт хувь нэмэр оруулж байгаа компаниудын нэг жишээ болгодог. Монголын Алт ХХК, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Чинхуа групп 50:50 хувийн хөрөнгө оруулалттайгаар тус компанийг 2002 онд үүсгэн байгуулжээ. Нарийн сухайтын чулуун нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 850 км, Өмнөговь аймгийн төвөөс баруун урагш 300 км, Шивээхүрэнгийн боомтоос хойш 56 км зайд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын IV багийн нутаг дэвсгэрт оршдог. Тус уурхай 2003-2011 онд нийт 10.1 сая тонн нүүрсийг Нарийн сухайтын ордоос олборлон БНХАУ-д экспортлоод байна. Өнгөрсөн хугацаанд тус компани улс, аймаг, сум орон нутгийн төсөвт нийт 18.3 тэрбум төгрөгийн татвар, төлбөр хураамжийн хэлбэрээр оруулжээ.

Үүнээс улсын төсөвт 14.3 тэрбум төгрөг, аймгийн төсөвт 3.4 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжилд зарцуулаад байгаа ажээ. Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий Алтан-Эко ХХК-аар хийлгэж, хамрагдвал зохих бүх объектод үнэлгээг хийлгэжээ. 2009 онд 1000 ширхэг заг, 5000 ширхэг мод тарьж, одоогийн байдлаар 8828 ширхэг мод ургаж байна. Мөн орон нутгийн хөгжилд дэмжлэг болгон БНХАУ-ын Сэхээ боомтоос Нарийн сухайтын уурхай хүртэл 35/10 Кв-ын 49.7 км, Нарийн сухайтын уурхайгаас Шивээ хүрэнгийн боомт хүртэл 55.02 км хатуу хучилттай зам барьсан байна. Нийт 93 км урт цахилгаан дамжуулах шугам, дэд станцыг барьж ашиглалтад оруулахад тус компани 2.8 тэрбум төгрөг буюу 2.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Нийгмийн үйлчилгээнд зориулан Гурвантэс сумын төвд "Хүүхэд залуучуудын соёл спортын төв"-ийн цогцолбор барилга, Шивээ хүрэнгийн шалган нэвтрүүлэх боомтын өндөр хүчдэлийн шугамд холбож, байнгын цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болов. Шивээхүрэнгийн хилийн боомтын гаалийн хорооны бүрдүүлэлтийн цэгийг Улаанбаатар хот дахь Гаалийн ерөнхий газартай онлайн системд холбох ажилд зориулж 9.9 сая төгрөгийн хөрөнгө гаргаж, гүйцэтгэсэн ажээ. Нийт 144 ажилтантайгаас 39 хувийг нутгийн иргэдээс бүрдүүлсэн байна.

Гэхдээ Хятад улсын хөрөнгө оруулалттай компаниудын дотор байгаль орчныг бохирдуулах, татвараас зайлсхийх зэрэг монголын талын дургүйцлийг төрүүлэх явдал гарсаар байна. Тухайлбал, Шиньшинь ХХК Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, хар тугалга, цайрын хүдрийн олборлолт, экспорт хийдэг. Монголоос 2011 онд хамгийн их экспорт хийсэн уул уурхайн компаний 31-д жагссан. Тус компани Дорнод аймгийн Дашбалбар, Баяндун сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, 2004 оноос холимог металлын баяжуулах үйлдвэрийн цогцолборыг барих ажлаа хайгуулын үйл ажиллагаатай хамтатган явуулж, 2010 онд ашиглалтын горимд орсон далд уурхайтай юм. "Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах сан" ТББ-аас хийсэн мониторингийн тайланд дурьдсанаар Шиньшинь ХХК баяжуулах үйлдвэрийн цогцолбор байгууламж барих хугацаанд байгаль орчны нөхөн сэргээлт хийх стандартыг мөрдлөг болгоогүй ба биологийн нөхөн сэргээлтийг орхигдуулсан нь илэрсэн байна.¹⁸ Үүнээс шалтгаалан 2006-2010 онуудад ургамал бүрхэвч 60-70 хувь, хагд бараг байхгүй, халцгай газар 18-30 хувь байсан бол 2007 онд ногоон ургамал 20 хувь болон буурч, хагд 49 хувь болон өсчээ. Мөн тус компаний үйлдвэрийн шингэн хаягдлын далан 2010 онд сэдэрч, 2 км тууш газар урсаж хөлдсөн нь Мухрын хөндийн хөрсийг бохирдуулсан байна. Хүдрийн баяжмалыг өдөр бүр 60 тн-ны хүнд даацын машинаар 180 км газар Монгол, Хятадын Хавирга, Архашаатын хилийн боомт руу зөөвөрлөж байгаа нь шороон авто замыг өргөсгөж, тоосжих, хөрсний ургамлын бүтэц алдагдах нөхцлийг бүрдүүлсэн аж. Шиньшинь ХХК-ийн охин компани болох Шинь Ирвис ХХК "Гол мөрний урсац, булгийн эхэнд ашигт малтмалын хайгуул олборлолтын үйл ажиллагаа явуулахыг хориглосон" хуулийн заалтыг зөрчин Онхоодой булгийн эхэнд өрөмдлөг хийж, нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгаран үйл ажиллагаагаа зогсооход хүрчээ.

Уул уурхайн компаниуд байгаль орчны нөхөн сэргээлтийг хангалттай хийдэггүй, ажлын явцад стандарт мөрддөггүй зэрэг нь тухайн компанийн нийгмийн хариуцлагагүйтэй холбоотойгоос гадна сум, орон нутгийн удирдлагууд аж ахуйн нэгжүүдийн хийсэн тайланд дүгнэлт хийж ажилладаггүй, байгаль орчны байцаагч нар компанийн байгаль орчны нөхөн

сэргээлтэд хяналт тавиагүй, үндсэн үүрэгтээ хайхрамжгүй хандаж, компаниудын гаргаж өгсөн тайлан мэдээ баримт бичгүүдийг нягтлан үзэж, бодит байдалтай харьцуулан үзэлгүй гарын үсэг зурдаг, ашигт малтмалыг зөөх авто машины замыг холбогдох байгууллагуудаар баталгаажуулан чиглэлийг тогтоож мөрдөөгүй зэрэгтэй шууд холбоотой ажээ.

Хятадын бас нэг томоохон хөрөнгө оруулалттай компани болох Петрочайна дачин тамсаг ХХК байгаль орчныг ихээр бохирдуулж Дорнодын тал газрыг сүйтгэж байгаа ажээ. Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвслийн нэхэмжлэлтэй тус компанид холбогдох хэргийг шүүх 2012 оны 7-р сард хэлэлцээд, Петрочайна дачин тамсаг компаниар Монголын байгаль орчинд их хэмжээний хохирол учруулсны нөхөн төлбөр болох 1.3 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэхээр болсон байна.¹⁹

Петрочайна дачин тамсаг ХХК-ийн төлсөн нийт татвар 2007-2011 оны байдлаар

Төрөл		2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он
Олборлолт	bbl	575 490	1 002 874	1 358 020	1 606 975	2 067 666
Экспорт	bbl	564 826	1 324 646	1 324 646	1 555 624	2 019 931
Нийт татвар	сая төг.	1 274.3	1 637.2	2 075.5	3 693. 9	1 245.3

Хүснэгтээс харахад 2011 онд тус компанийн олборлолт, экспорт 2009 оныхоос бараг хоёр дахин нэмэгдсэн байтал төлсөн татвар нь хоёр дахин багассан нь ажиглагдлаа. Эдгээрээс дүгнэхэд нийгмийн хариуцлага хамгийн сайтай байх учиртай Хятадын төрийн өмчит том компани болох Петрочайна дачин тамсагийн үйл ажиллагаа улам суларч, татвар төлөлт бууран, байгаль орчин сүйтгэсэн сөрөг үзэгдлүүд гаргасаар байна.²⁰ Мөн Хятадын хөрөнгө оруулагчид манай улсын баялгийг түүхийгээр нь ямар ч анхан шатны боловсруулалт хийхгүй шууд урагшаа зөөж байна. Иймд уул уурхайн болон мал аж ахуйн түүхий эдийг эх орондоо эцсийн боловсруулалт хийж гадаад зах зээлд гаргах эрх зүйн зохицуулалт хийх,

ингэхдээ урд хөршийнхөө сонирхлыг харгалзах, тэгш тэнцүү байдлыг хангах, харилцан ашигтай байх зарчмаар шийдэх шаардлагатай байна.

1. БНХАУ-аас Монгол Улсад үзүүлсэн буцалтгүй тусламж

Хятадын ард түмэн Монголын ард түмэнд элэгсэг дотно, найрсаг ханддагийн илэрхийлэл болгож тусламжийн гараа харамгүй сунгадаг бөгөөд тэдгээр тусламж нь Монгол улсын хөгжил дэвшилд их хувь нэмэр болдог төдийгүй цаг агаарын хүндрэл болон гоц халдварт өвчин зэрэг онцгой нөхцөл байдал тохиолдсон үеийг даван туулахад ихээхэн тус болдог билээ. Тэдгээр тусламжуудаас жишээ болгон дурдахад, 2001 онд Монгол улсад тохиолдсон өвөлжилтийн хүндрэл, зудын гамшгийг даван туулахад зориулан Хятадаас 5 сая юаний буцалтгүй тусламжийг олгож байв.

Хятадаас Монголд өгч буй буцалтгүй тусламжийн давтамж болон тоо хэмжээ улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд зөвхөн 2002 онд л гэхэд Монгол улсын ерөнхий сайд Н.Энхбаярын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр 50 сая юань, Хятадын худалдааны яамны сайд Ши Гуаншэн сайд Монгол улсад айлчлах үедээ 10 сая юань, Батлан хамгаалах яамны шугамаар 8 сая юань, чөлөөт бүсийн туршлага судлахад зориулж 800 мянган юань, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын барилга болон бусад төсөлд зориулж 4 сая ам.долларын буцалтгүй тусламжуудыг Хятадын засгийн газраас манай улсад үзүүлсэн юм. Хамгийн сүүлд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 оны 10-р сард БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр байгуулсан «Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр»-ийн дагуу Хятад улсаас манай улсад 50 сая юанийн буцалтгүй тусламж үзүүлэхээр болсон билээ.²¹

БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт 2000 оноос хойш нийт 600 орчим сая юаний тусламжийг мөнгөн хэлбэрээр олгосон²² бөгөөд тэдгээр хөрөнгөөр бүтээн байгуулалтын олон төсөл хэрэгжсэн. Энхтайвны гүүр, Биеийн тамирын спортын ордны барилгыг засварлах тухай саналыг монголын талаас тавьсанаас Энхтайваны гүүрийг засварлан

хүлээлгэж өгч, спортын төв ордны барилга нь 1960-аад оны үед баригдсан тул засвар хийхэд хүндрэлтэй гэж үзэж шинээр барихаар шийдсэн. 2008 онд Си Зиньпин даргын Монгол улсад хийсэн айлчлалын үеэр сууриа тавьсан 5000 хүний суудалтай, 15 мянган кв.м талбайтай Биеийн тамир, спортын ордон нь Хятадын буцалтгүй тусламжаар Монголд хэрэгжсэн хамгийн том барилгын төсөл бөгөөд 2010 онд дуусгаж хүлээлгэн өгсөн юм. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн барилга болон ахмадын орон сууц төслүүд 2009 онд хэрэгжиж дуусчээ.

БНХАУ-аас Монгол Улсад үзүүлсэн буцалтгүй тусламжийн үлдэгдэл хөрөнгө 372.2 сая юанийг²³ Монгол улсын Засгийн газрын 2012 оны 4-р сарын 4-ний өдрийн хуралдаанаас Хятадын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх доорхи төслүүдийн санал гарсаныг Хятадын тал хүлээн авсанаа хариу мэдэгджээ. Үүнд:

- Нийслэлийн Бээжингийн нэрэмжит гудамжны тохижилт. Энэ төслийн өртөг 39 сая юань.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Нэгдсэн лабораторын барилгын нэмэлт санхүүжилт.
- Нарантуул захын баруун уулзвар болон төмөр зам дээгүүрх гүүрэн гарц.
- Гаалийн төв лабораторын барилгыг шинээр барих, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг боомтын вагон, чингэлэг шалгах рентгений тоног төхөөрөмж худалдан авах.
- Нийслэл хотод сургууль цэцэрлэг барих. Нийслэлийн Баянгол дүүргийн 38,73,47,57 дугаар сургуулиуд, Баянзүрх дүүргийн 146, Сонгинохайрхан дүүргийн 26-р цэцэрлэгийн ашиглалтын хугацаа дууссан тул БНХАУ-ын буцалтгүй тусламжаар суурин дээр нь шинээр сургууль цэцэрлэг барих ажлыг зохион байгуулах үүргийг Нийслэлийн боловсрол болон Өмчийн харилцааны газруудад өгсөн.²⁴

Хятадын засгийн газраас Монгол улсад тогтмол үзүүлж буй буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, түүний үр өгөөжийг жирийн иргэдэд сайн сурталчилж мэдээлж байх хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. Хятадын ард

түмний найрсаг сэтгэлийн илэрхийлэл болгон өгч байгаа зээл, тусламжийн талаарх мэдээллийг Монголын ард түмэнд илүү сайн хүргэснээр хоёр орны ард түмэн бие биендээ хандах хандлагад илүү сайнаар нөлөөлж цаашлаад хоёр орны харилцаа улам илүү хөгжихөд ач тустай юм.

2. БНХАУ- аас Монголд олгож буй хөнгөлөлттэй зээл

Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны салшгүй чухал хэсэг бол БНХАУ-аас Монгол улсад олгож буй зээл, тусламж, түүгээр хэрэгжүүлж буй төслүүд байдаг. Хоёр орны хөгжлийн хамтын ажиллагаанд төсөл, хөтөлбөрийг тохиролцдог тогтсон тусгай механизм байхгүй бөгөөд төрийн дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаанаар зээл, тусламжийн хэмжээ, зориулалтыг хэлэлцэн тохиролцдог. БНХАУ Монгол улсад олон удаагийн ихээхэн хэмжээний хөнгөлөлттэй зээл олгосон бөгөөд хөнгөлөлттэй зээлээр амжилттай хэрэгжсэн 1 төсөл, одоо хэрэгжиж буй 2 томоохон хөнгөлөлттэй зээлийн талаар товч танилцуулья.

БНХАУ-ын Дарга Ху Зиньтао 2003 онд Монгол Улсад айлчлахдаа 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, Ерөнхий сайд Вэнь Зябао 2010 онд айлчлах үеэрээ 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл тус тус олгосон юм.

300.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл: Хятадаас үзүүлж буй хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслүүдийн тооцоо судалгааг Монголын тал эхнээс нь нягт сайн хийгээгүйн улмаас зарим төсөл цуцлагдах, мөн хэрэгжүүлж буй төслүүд янз бүрийн саад бэрхшээлийн улмаас удаашрах явдал гардаг. Жишээ нь, 2003 оны 300 сая долларын хөнгөлөлттэй зээлийг эхлээд Эгийн голын усан цахилгаан станц барихад зориулахаар шийдсэн. Гэвч харамсалтай нь 2008 онд уг төслийг хэрэгжүүлэх өртөг нь олгосон зээлээс давсан, мөн үйлдвэрлэн гаргах цахилгааны өртөг нь Орос улсаас импортолж байгаа цахилгааны үнээс ч өндөр тооцоо гарсан гэсэн үндэслэлээр Монгол улс уг цахилгаан станцыг барих төслийг зогсоох шийдвэр гаргажээ. Монголын тал

энэхүү зээлийг хоёр ард түмний нүдэнд харагдахуйц, үр ашгаа харьцангуй богино хугацаанд нөхөхүйц төслүүдэд ашиглах хүсэлтэй буйгаа илэрхийлэхэд Хятадын тал зөвшөөрсөн. Гэхдээ тухайн зээлийг бүр 2003 онд олгохоор тохиролцсон боловч асуудал шийдэгдэхгүй өдий хүрч байгаад Хятадын Засгийн газар санаа зовж байгаагаа илэрхийлж тэрхүү зээлийг ашиглах шинэ төслөө монголын тал даруй гаргаж өгөхийг хүсч байв.²⁵ Энэхүү байдлаас харахад Монголын тал аливаа асуудалд хариуцлагагүй хандаж, тооцоо судалгаагаа нягт нямбай боловсруулаагүй, цаг хугацаа нэлээд алдсаны дараа өмнөх шийдвэрээ цуцлах санал тавьж байна гэдэг бол наанадаж тухайн хариуцсан яам тамгын газар, цаашлаад улс орны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх зүйл гэдгийг анхааран, цаашид тийм алдаагаа давтахгүй байхыг анхаарах хэрэгтэй болов уу.

Энэхүү 300 саяын зээлийн асуудал нэлээд удааширсаны эцэст 2011 оны 6-р сард Улаанбаатар хотноо болсон Засгийн газар хоорондын комиссын 12-р хуралдааны үеэр хөнгөлөлттэй зээлийг зориулах төслүүдийг тохиролцож дэс дараатай хэрэгжүүлэхээр болсон юм.

Монгол улсын Сангийн яам болон БНХАУ-ын Экспорт-Импорт банкны хооронд 2008 оны 6-р сарын 19-ний өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Монгол улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2005 оны 11-р сарын 28-ны өдөр байгуулсан 300.00 сая ам долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтын талаарх Зээлийн ерөнхий хэлэлцээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг Монгол Улсын УИХ 2008 оны 12-р сарын 4-ний өдөр соёрхон баталсанаар энэхүү зээлийн ашиглалт эхэлсэн байна. Зээлийн нөхцлийн хувьд жилийн 1.75 хувийн хүүтэй, нийт 20 жилийн хугацаанд буцаан төлөхөөс эхний 7 жил үндсэн төлбөр (хүүг төлнө)-өөс чөлөөлөгдөж, төслийн өртгийн 85 хувийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж, үлдсэн 15 хувийг Монголын тал санхүүжүүлэх нөхцөлтэй. Үүнд зориулж улсын төсвөөс 50 сая орчим ам.долларын хөрөнгийг 2011 онд Хятадын ЭКСИМ банкин дахь хэрэгжүүлэгч компанийн дансанд бүрэн шилжүүлжээ.

300.0 сая ам.долларын зээлийн хүрээнд нийт 5 төслийг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу төслүүдийн худалдан авах ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч яамдууд зохион байгуулж, Хятадын ЭКСИМ банкнаас зөвшөөрөл авснаар Тусгайлан зээлийн хэлэлцээрийг төсөл тус бүр дээр Сангийн яам, ЭКСИМ банкны хооронд байгуулдаг, ингэхдээ Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, Сангийн сайд гарын үсэг зурах эрхийг олгодог. Төслүүдийн хэрэгжилт 2011 оны сүүлээр жигдэрч, бодит ажлууд 2012 оны хавраас хийгдэж эхэлсэн, төсөл 2014 он хүртэл хэрэгжинэ. Үүнд:

1. Орон сууцны хороолол, дэд бүтэц (117.5 сая ам.доллар)
2. Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах (58.8 сая ам.доллар)
3. Баруун босоо тэнхлэгийн авто зам барих (58.8 сая ам.доллар)
4. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн хэсгийн парк шинэчлэл (64.3 сая ам.доллар)
5. Мэдээлэл харилцаа холбооны үндсэн сүлжээний өргөтгөл (45.7 сая ам.доллар)

Эдгээр төслийн хэрэгжилтийг нарийвчлан үзвэл:

"Орон сууцны хороолол, дэд бүтэц" төсөл. Улаанбаатар хотын 7-р хороолол, Радио телевизийн орчмын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ, 7, 14-р хороололд баригдах 2152 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Инженерийн шугам сүлжээний угсралтын ажилд 40 сая ам.доллар, орон сууцны барилгын угсралтын ажилд 60 сая ам.долларыг зарцуулахаар тооцсон. 2010 оны 3-р сарын 16-ны өдөр зарласан тендерийн баримт бичигт монголын талын хариуцах хувийг тусгаагүй байсан учир одоогоор уг алдааг засахаар дахин тендер зарлаад байна.

"Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах" төсөл. Төслийн тендер зарлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 58.8 сая долларын гэрээ байгуулаад байна. Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн нийт 900 га талбайн 278.62 га буюу 30.9 хувь нь, Замын-Үүдийн тосгоны 300 га газар дэд бүтцэд бүрэн хамрагдах болно. Төслийн хүрээнд дулааны станц, дулааны шугам сүлжээ,

усан хангамж, ариутгах татуургын байгууламж, авто зам, холбооны байгууламж гэх мэт нийт 4 багц ажил хийгдэнэ. Төсөл хэрэгжсэнээр Дорноговь аймгийн Замын-Үүд сум, "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалт, бүс нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмж, ард иргэдийн амьдрах орчин, ер нь улс орны эдийн засгийн хөгжилд бодитой түлхэц өгөх юм.

Баруун бүсийн авто замыг хөгжүүлэх төсөл. Манхан-Ховд чиглэлийн 85.3 км хатуу хучилттай авто зам, Өлгий-Хашаат чиглэлийн 60.0 км хатуу хучилттай автозамын гүйцэтгэгчээр БНХАУ-ын China Gezhouba Group Company limited компани шалгарч, 2010 оны 8-р сарын 4-ний өдөр Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамтай гэрээ байгуулсан. Барилгын ажлын хөрөнгийн 85 хувь буюу 50 сая ам долларыг БНХАУ-ын засгийн газар, 15 хувь буюу 8.83 сая ам.долларыг Монголын засгийн газар санхүүжүүлнэ. Мөн түүнчлэн Монголын тал Өлгий-Хашаат чиглэлийн 60.0 км авто замыг барих ажилд хяналт тавьж, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх ажлыг 380.0 мянган ам.доллараар санхүүжүүлнэ. Дээрх чиглэлийн авто зам баригдсанаар Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаар хийх ачаа, зорчигч тээвэрлэлт, нэмэгдэж, бүс нутгийн худалдаа эдийн засгийн хөгжилд өсөлт гарна.

"Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх" төсөл. Төслийн хүрээнд ЗТБХБЯ-аас 2 багц бүхий тендер зарлаж, "China CNR Corporation Limited", "China Same Engineering Co.,Ltd" компаниуд оролцсон. 1-р багцад гол замын 5 зүтгүүр, ачааны 245 вагон, сэлгээний 1 зүтгүүр, 2 контейнер ачигч бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх нийт 39.35 сая ам долларын төсөвт өртөгтэй худалдаж авах ажил багтсан болно. Замын-Үүд дэх шинэ терминалын зураг төсөл зохиох, барилга угсралтын ажил гүйцэтгэх 2-р багцад "Замын – Үүд дэх шинэ терминалын зураг төсөл зохиох, барилга угсралтын ажил гүйцэтгэх" 20.65 сая ам.долларын төсөвт өртөгтэй ажил орсон боловч өнөөг хүртэл гэрээ байгуулагдаагүй байна. Энэ хугацаанд "China CAMC Engineering Co.,Ltd" компани тооцоо судалгааг шинээр хийж ажлын хэсэгт танилцуулсан боловч анх тендерийн баримт бичигт тусгагдсан зарим ажлыг хасч ирүүлсэн тул гэрээ байгуулах боломжгүй болж дахин хэлэлцээр хийж байна.²⁶

500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл: БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао 2010 оны 6-р сард Монгол улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол улсын засгийн газарт 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох боломжтой гэж мэдэгдсэн. Үүний дагуу техникийн түвшинд хэд хэдэн удаагийн уулзалт, хэлэлцээг явуулсны дүнд 3 салбарт нийт 13 төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон. Зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2011 оны 6-р сарын 9-ний өдөр байгуулж, УИХ-аар 2011 оны 7-р сарын 9-ний өдөр соёрхон баталжээ. Зээлийн нөхцлийн хувьд жилийн 2 хувийн хүүтэй, нийт 20 жилийн хугацаанд буцааж төлөхөөс эхний 7 жилд үндсэн төлбөр (хүүт төлнө)-өөс чөлөөлөгдөнө. Хятадын талын зээлийн хөрөнгөөр төслийг 100 хувь санхүүжүүлэхээр тохиролцсон бөгөөд харин зээлийн хүрээнд санхүүжиж буй төслүүдийг гааль, НӨАТ-аас бүрэн чөлөөлнө. ²⁷

Зээлийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүд

	Төслийн нэр	Хэрэгжих хугацаа	Дүн Сая. ам.долл.	Тайлбар
1	Мах боловсруулах үйлдвэр, Хүнсний бөөний төв барих	2013-2015	112.4	2 удаа тендер зарласан боловч үнийн саналууд төсөвт өртгөөс хэтэрсэн тул шууд гэрээ байгуулах хэлэлцээ хийгдэж байна.
2	Хуурай сүү боловсруулах үйлдвэр барих, сүүний үйлдвэрүүдэд хөргөлтийн тоног төхөөрөмж нийлүүлэх	2013-2014	14.1	
3	Гурилын үйлдвэр, элеватор барих	2013-2014	20.5	
4	Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах	2012-2013	40.0	Хэрэгжиж байгаа
5	Чацаргана боловсруулах үйлдвэр барих	2013-2014	13.0	Тендерийн саналыг үнэлэх ажил хийгдэж байна.
6	Цахим эрүүл мэнд	2013-2014	19.6	Ойрын үед төслийн тусгайлан зээлийн хэлэлцээрийг байгуулна.
7	Шинэ зууны боловсрол	2013-2014	46.2	Тендер зарласан, үнэлгээг хийсэн. Хятадын компани шүүхэд гомдол гаргаснаас зогсонги байдалд орсон

Д.Дагийсүрэн

8	Баруун 4 замын солбилцол	2013-2014	52.5	Тендер зарлагдсан. НЗДТГ дээр үнэлгээний хороо байгуулан ажиллуулах шаардлагатай.
9	Баянбүрдийн замын тойргийн солбилцол	2013-2014	42.1	
10	Салпорогийн замын тойргийн солбилцол	2013-2014	37.1	
11	Сонсголонгийн уулзвар	2013-2014	46.3	
12	Замын цагдаагийн газрын ойролцоох уулзвар	2013-2014	37.4	
13	Яармагт шинэ гүүр барих, засварлах	2013-2014	18.8	

"Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах" төслийн хүрээнд тусгайлсан зээлийн хэлэлцээрийг Сангийн яам, Хятадын Экспорт-Импорт банктай 2012 оны 5-р сарын 10-ны өдөр байгуулж, төслийн хүрээнд эхний ээлжийн 8000 трактор нийлүүлсэн. Төслийн тендерээс хэмнэгдсэн 12.3 сая ам.долларын хөрөнгөөр хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах хүсэлтийг Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам тавьжээ. Дээрх зээлүүдийг жижиг, дунд боловсруулах үйлдвэр болон дэд бүтцийг сайжруулахад зарцуулахаар болсон нь сайшаалтай санагдаж байна.

Хятадын хөнгөлөлттэй зээлийг хамгийн үр дүнтэй ашигласан сайн жишээ бол Төмөртэйн овооны цайрын ордны үйлдвэр юм. 1998 оны 12-р сарын 11-ний өдөр байгуулсан Хятад улсаас Монгол улсад хөнгөлөлттэй зээл олгох тухай БНХАУ-ын засгийн газар, Монгол улсын засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн дагуу Монгол улсад 100 сая юаний хөнгөлөлттэй зээлийг үйлдвэрлэлийн шинж чанартай төсөлд олгож ашиглуулахаар хэлэлцэн тохиролцсоны дагуу манай улсад олгох 100 сая юаний хөнгөлөлттэй зээлийг Сүхбаатар аймгийн Төмөртэйн овооны цайрын үйлдвэрийн төсөлд ашиглахыг 1999 оны 6-р сард хуралдсан хоёр улсын засгийн газар хоорондын комиссын VI хуралдаан, 1999 оны 9-р сард хуралдсан Гадаад харилцааны яамны дэргэдэх Гадаадын зээл, тусламжийг зохицуулах Зөвлөлийн хурал, 1999 оны 10-р сард хуралдсан засгийн газрын ээлжит хуралдаанаар дэмжсэн шийдвэрийг гаргасан.²⁸ БНХАУ-ын засгийн газар хоёр орны худалдаа-эдийн засгийн харилцааг хөгжүүлж, найрамдалт харилцааг гүнзгийрүүлэх зорилгоор Төмөртэйн цайрын ордыг ашиглахад зориулан дахин 100 сая юанийн зээл олгохоор

шийдвэрлэж тэрхүү ордыг ашиглахад нийтдээ 200 сая юанийн хөрөнгө оруулалт хийхээр болсон.²⁹ "Ашигт малтмалын тухай" хуулийн дагуу Монгол улсын "Металлимпекс" ХХК Төмөртийн овооны ашиглалтын лицензийг авч, улмаар БНХАУ-ын өнгөт төмөрлөгийн гадаад барилга, зураг төслийн компанитай уг ордыг хамтран ашиглах гэрээг 1997 оны 11-р сард байгуулж, энэхүү төслийг хэрэгжүүлэх нэгдсэн үүрэг бүхий Монгол Хятадын хамтарсан "Цайртминераль" ХХК-ийг үүсгэн байгуулж, уг үйлдвэрийн шав тавих ёслолыг 2000 оны 4-р сард хийж, 5 жилийн дараа 2005 онд ашиглалтанд оржээ. Техник эдийн засгийн үндэслэлийн дагуу жилдээ 300 мянган тонн цайрын хүдэр боловсруулах хүчин чадалтай, ашиглалтын хугацаа 27 жил, нэг жилд 18 сая орчим ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий уул уурхайн баяжуулах үйлдвэрийг Хятадын талын оролцогчийн зээлийн хөрөнгөөр "Түлхүүр хүлээлгэн өгөх" нөхцлөөр барьж байгуулан ашиглалтанд оруулсан. Хятадын тал өөрөө үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдан авагч байх нөхцлийг хангасан энэхүү үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулснаар экспортын эх үүсвэр, төсвийн орлого нэмэгдэж, ажлын байр шинээр бий болж, бүс нутгийн хөгжилд багагүй хувь нэмэр болсон.³⁰

Дүгнэлт

БНХАУ-аас оруулж буй хөрөнгө оруулалт манай улсын эдийн засгийг хөгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулж буй гэдэгтэй маргах хүн үгүй бизээ. Тиймээс энэхүү хөрөнгө оруулалтыг эдийн засгийн чухам аль салбарт түлхүү оруулахыг нухацтай бодолцож, хөрөнгө оруулалтын зерэг болон сөрөг талуудыг сайтар судлах нь чухал. Хөрөнгө оруулалтыг харилцан үр ашигтай, тогтвортой зөв зохистой оруулах нь манай хоёр орны эдийн засгийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхээс гадна хоёр орны ард түмний итгэлцэл, эв найрамдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. Гадаадын хөрөнгө оруулалт бол Монголын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хөгжлийг хурдасгах гол хүчин зүйл учир уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулж, нэмүү өртөг бий болгох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх том том үйлдвэрүүдийг

байгуулахад болон дэд бүтэц, зам тээврийн хөгжилд Хятадын хөрөнгө оруулалтыг түлхүү татах нь зүйтэй гэж үзэж байна. Ингэхийн тулд Монгол улс бизнесийн харьцангуй чөлөөт байдлыг бий болгосон гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, түүнийг хөхүүлэн дэмжих бодлогоо тууштай, тогтвортой баримтлах хэрэгтэй.

БНХАУ-аас манай улсад олгож байгаа хөнгөлөлттэй зээл гэдэг бол хэсэг хугацааны дараа эргэн төлөгдөх ёстой өр гэдгийг сайн ухамсарлаж, зээлийн зарцуулалт, ашиглалтанд ихээхэн анхаарал хандуулж хугацаанд нь төлж барагдуулах цаг хугацаа, графикийг нарийн гаргахгүй бол хэсэг хугацааны дараа маш их өрийн дарамтанд орох эрсдэлтэй билээ. Монгол улс Хятадаас олгосон зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн ажилд хойрго хандаж, хугацаа нилээн алддаг хэмээн Хятадын тал шүүмжилдэг. Тэр нь ортой тул Монгол улс цаашид Хятадаас авч байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслөө анхнаас нь нарийн төлөвлөж цаг хугацаанд нь амжуулан хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Засгийн газрын түвшинд өмнө нь Хятадаас авсан зээлийн хэмжээ Монгол Улсын гадаад өрийн багцад өнөөгийн байдлаар хамгийн их байгаад болгоомжтой хандах нь зүйтэй юм. Цаашид шинээр зээл авах тохиолдолд ажиллах хүчний асуудлыг (тухайлбал ажилчдын тооны хязгаарын талаар Хөдөлмөрийн яамтай, ажиллах хүчний визний талаар Гадаадын иргэний харьяатын асуудал эрхэлсэн газартай тус тус уялдуулах) зээлийн Ерөнхий хэлэлцээрт хэрхэн тусгах талаар санал боловсруулах шаардлагатай.

Хятадын засгийн газраас Монгол улсад олгож байгаа буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа төслүүдийг монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонин хэвлэлээр ард түмэнд танилцуулах тал дээр анхааран идэвхитэй ажиллах хэрэгтэй юм. Ингэснээр ард түмэнд илүү хүрч хоёр орны ард түмний найрсаг харилцаа бэхжихэд их ач тустай.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

- ¹ Улсын Их хурлын тамгын газар "Судалгааны эмхэтгэл" УБ хот, 2013 он 39-р тал
- ² Хөрөнгө оруулалтын тухай хууль www.investmongolia.com
- ³ Хөрөнгө оруулалтын тухийн тухай <http://economics.eagle.mn/content/read/4697.htm>
- ⁴ Улсын Их хурлын тамгын газар "Судалгааны эмхэтгэл", УБ хот, 2013 он 41-р тал
- ⁵ "Эрдэм шинжилгээний бичиг", МУИС, ОУХС, УБ хот 2011 он, 87-р тал
- ⁶ Хуан Ин "Хятад, Монголын түншлэлийн харилцааг стратегийн өндөрлөгөөс харах нь" Стратеги судлал 2010 он 43-р тал
- ⁷ 2010 年度中国对外直接投资统计公报 <http://hzs.mofcom.gov.cn/Accessory/201109/1316069604368.pdf>
- ⁸ **Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал**
- ⁹ Улсын Их хурлын тамгын газар "Судалгааны эмхэтгэл", УБ хот 2013 он 42-р тал
- ¹⁰ Б.Ганзориг, Д.Начин "Гадаадын хөрөнгө оруулалтын байдал ба хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогыг хэрэгжүүлэх арга замууд" Стратеги судлал сэтгүүл 2012 он №1,83-р тал
- ¹¹ ГХОГ <http://www.investmongolia.com/fiftanew/images/PDF/Publication/Statistics/Statistic%202010FIFTA.pdf>
- ¹² "БНХАУ-ын эрчим хүчний эрэлт, Монгол-Хятадын уул уурхайн салбарын харилцаа" Улаанбаатар хот, 2013 он 85,86-р тал
- ¹³ Улсын Их хурлын тамгын газар "Судалгааны эмхэтгэл", УБ хот, 2013 он 42-р тал
- ¹⁴ www.mongolianminingjournal.com
- ¹⁵ <http://www.president.mn/mongolian/node/670>
- ¹⁶ Монгол улсын гадаад харилцааны яам, Бүс нутаг дахь «Монгол Улс, БНХАУ-ын хамтын ажиллагаа» илтгэл, 2009
- ¹⁷ Улсын Их хурлын тамгын газар "Судалгааны эмхэтгэл", УБ хот, 2013 он 81-р тал

- 18 "Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах сан" ТББ Шиньшинь ХХК-ий үйл ажиллагаанаас
- 19 <http://www.news.mn/content/113117.shtml> Петрочайнагийн торгуулийг хэвээр батлав
- 20 Стратегийн судалгааны хүрээлэн, "БНХАУ-ын эрчим хүчний эрэлт, Монгол-Хятадын уул уурхайн салбарын харилцаа" УБ 2013 он 95-р тал
- 21 Ерөнхий сайдын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд ямар асуудлууд шийдэгдэв? <http://www.zasag.mn/news/view/3442>
- 22 **Хятадын Засгийн газар 50 сая юаний буцалтгүй тусламж үзүүлнэ** <http://www.24tsag.mn/content/17830.shtml>
- 23 <http://mof.gov.mn/2013/09/>
- 24 Монгол улсын Гадаад харилцааны яамны төв архивын материал ХНН№112, Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, Танилцуулах мэдээ №07/37, 154-р тал
- 25 Гадаад харилцааны төв архивын материал, №60, 2008 оны Монгол Хятадын харилцаа 2 боть, Улаанбаатар 2009 он, 2008 оны 2-р сарын 27-ны өдөр Элчин сайд Г.Батсүх, БНХАУ-ын ГХЯ-ны Азийн газрын дарга Гоухунтай уулзсан тэмдэглэлээс... 58-р тал
- 26 <http://www.slideshare.net/MunkhOrgil/10-5791421>
- 27 Гадаад харилцааны төв архивын материал, ХНН№113, Монгол улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засаг, уул уурхайн салбарын харилцаа 2012 он, Улаанбаатар 2013 он 155-р тал
- 28 Гадаад харилцааны төв архивын материал №1 2000 оны Монгол, Хятадын улс төрийн харилцааны баримт бичиг Улаанбаатар хот МУ-ын ГХЯ 2000.11.20-ны өдрийн танилцуулах мэдээ, 5-р тал
- 29 Гадаад харилцааны төв архивын материал №1 2000 оны Монгол, Хятадын улс төрийн харилцааны баримт бичиг, Улаанбаатар хот, 2000.10.19-нд БНХАУ-аас МУ-д суугаа элчин сайд Хуан Зякуй Монгол улсын ерөнхий сайд Н.Энхбаяртай уулзсан тэмдэглэлээс..., 25-р тал
- 30 Гадаад харилцааны төв архивын материал, Монгол, Хятадын улс төрийн харилцааны баримт бичиг ХНН№2 Улаанбаатар хот Санхүү эдийн засгийн яам 38-р тал

The summary of Government grant aid and soft loans from the People's Republic of China to Mongolia since 2000

Abstract: Chinese loan and grant aids to Mongolia and their funded projects are counted as an inseparable part of the Mongolian & Chinese trade and economical cooperation. In this article, I included detailed information about grant aid and easy term loans from China to Mongolia, and which project, programs had been funded by them and my conclusion about the positive and negative outcomes of those.

Our country's economy still has insufficient source of money, therefore foreign grant aid and loans remain important. Last few years, Chinese investment to our country has been continuously growing. However, we did not have a precise analysis how we are spending the money, hence I have decided to contribute in, by writing the summary of grant aid and easy term loans from China to Mongolia.

Keyword: China, Mongolia, loan, easy term loan, grant aid, positive side, negative side